



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/43

Улаанбаатар хот

Салбаруудын бүтцэд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 45 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн үйлчилгээний газруудыг манай байгууллагын харьяанд шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах, тэдгээртэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах зорилгоор Баруун, Зүүн салбар тус бүрт Нийтэд үйлчлэх хэсэг байгуулсугай.

2. Нийтэд үйлчлэх хэсэгт

а. Нийтийн бие засах газар б. Зайсан цогцолбор в. Нүхэн гарц
г. Төлбөртэй зогсоол д. Тамхины цэг е. Гүүрэн гарцыг тус тус
хамааруулсугай.


3. Нийтэд үйлчлэх хэсгийг байршлаар нь Баруун, Зүүн салбарт харьяалуулан ажилтнуудыг хуваарилж, орон тоо, албан тушаалын дээд хязгаарыг 1 дүгээр хавсралтаар, ажилтнуудын нэр, цалин хөлсийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Нийт лифтийг хариуцаж, лифтийн аюулгүй ажиллагааг хангах, гарсан эвдрэл гэмтлийг цаг тухай бүр нь түргэн шуурхай засварлах ажлыг Лифтийн техникч Ц. Даваажамцад даалгасугай.

5. Ажил хүлээлцэх актаар тухайн хэсэгтэй холбоотой зураг төсөл, бичиг баримтыг хүлээн авах, хэсгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, удирдан зохион байгуулах ажлыг Салбарын дарга /Б.Ганзориг, Б.Нямсүх/ нарт үүрэг болгосугай.

6. Хэсгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан танилцуулахыг Хүний нөөцийн мэргэжилтэн Ц. Лхагватуяад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН

0100000039
D:\A tushaal.docx